

Тахир дутуу иргэдийн нэг удаагийн бүртгэл, түүвэр судалгаа, 2004 он

Товч дүгнэлт

Монгол Улсын Үндэсний статистикийн газарт Азийн Хөгжлийн Банкны техникийн тусламжтайгаар хэрэгжүүлж байгаа Монгол Улсын “Нийгмийн статистикийг боловсронгуй болгох” төслийн хүрээнд тахир дутуу иргэдийн талаарх статистикийн мэдээллийг сайжруулах, үзүүлэлтийн тогтолцоо, аргачлалыг олон улсын жишигт нийцүүлэх зорилгоор тахир дутуу иргэдийн нэг удаагийн бүртгэл, түүвэр судалгааг 2004 оны 5, 6-р сард явуулсан.

Тахир дутуу иргэдийн нэг удаагийн бүртгэлийн дүнгээс үзэхэд (2004 оны 5 дугаар сарын 24-ний байдлаар) нийт 69263 тахир дутуу иргэн бүртгэгдэв.

Нийт хүн ам 2004 оны жилийн эхэнд 2504.0 мянган хүн болж, үүний 2.8 хувийг тахир дутуу иргэд эзэлж байгааг хүйсээр авч үзвэл 1261.7 мянган эмэгтэйчүүдийн 2.5 хувь нь, 1242.3 мянган эрэгтэйчүүдийн 3.1 хувь нь тахир дутуу хүмүүс байна. Нийт тахир дутуу иргэдийн 55.2 хувийг эрэгтэйчүүд, 44.8 хувийг эмэгтэйчүүд эзэлж байна. Тахир дутуу иргэдийн 44.9 хувь нь хотод 50.1 хувь нь хөдөөд амьдарч байна. Нийт 69.3 мянган тахир дутуу хүн бүртгэгдсэний 24.6 мянга буюу 35.5 хувь нь төрөлхийн тахир дутуу, 44.7 мянга буюу 64.5 хувь нь олдмол тахир дутуу хүмүүс байна.

Нийт тахир дутуу иргэд тахир дутуугийн хэлбэрээр, дотор эрхтэнийх (22.5 хувь), дараа нь бие эрхтэний-хөл (12.5 хувь) оюуны хомсдол хүнд (7.9 хувь), сул хараатай (6.8 хувь) байна.

Олдмол хэлбэрийн тахир дутуу хүмүүсийн 27.9 мянга буюу 62.6 хувь нь ердийн өвчнөөр, 3.9 мянга буюу 8.7 хувь нь мэргэжлээс шалтгаалах өвчнөөр, 1.2 мянга буюу 2.7 хувь нь үйлдвэрлэлийн ослоор, 7.1 мянга буюу 15.8 хувь нь ахуйн ослоор, 4.6 мянга буюу 10.2 хувь нь бусад шалтгаанаар тахир дутуу болжээ.

Нийт тахир дутуу хүмүүсийн 20.5 хувь нь бүрэн бус дунд боловсролтой, бага боловсролтой нь 19.5 хувь, өөрөөр хэлбэл энэ хоёр үзүүлэлт нийлээд 40 хувийг эзэлж байгаа юм. Боловсролгүй хүмүүсийн 72.6 хувь нь бичиг үсэг мэдэхгүй байна.

Тахир дутуу иргэдийн нэг удаагийн бүртгэлийн дүнгээр 7-29 насны нийт тахир дутуу иргэдийн дөнгөж 15.7 хувь, үүнээс эрэгтэйчүүдийн 14.0 хувь, эмэгтэйчүүдийн 17.7 хувь нь ямар нэг түвшний боловсрол олгох сургуульд суралцаж байна. Хүн ам орон сууцны 2000 оны улсын

тооллогоор 7-29 насны нийт хүн амын 47.8 хувь нь суралцдаг гэсэнтэй харьцуулахад тахир дутуу хүмүүсийн сургуульд хамрагдалт бага байна.

Арван тав, түүнээс дээш настай тахир дутуу хүмүүсийн (64806 хүн) 26.4 хувь, эрэгтэйчүүдийн 28.3, эмэгтэйчүүдийн 24.0 хувь нь ажил эрхэлж байна. Ажил эрхэлж байгаа тахир дутуу иргэдийн 56.9 хувь нь хувиараа ажиллагч, 16.4 хувь нь гэр бүлийн бизнест цалин хөлсгүй оролцогч, 12.8 хувь нь гэрээгээр ажиллагч байна. Тахир дутуу эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн дийлэнх нь хувиараа хөдөлмөр эрхэлж байгаа бөгөөд эмэгтэйчүүдийн 18.6 хувь, эрэгтэйчүүдийн 14.9 хувь нь гэр бүлийн бизнест цалин хөлсгүй оролцон ажиллаж байна.

Нийт тахир дутуу иргэдээс 88.4 хувь нь эмнэлэг, хөдөлмөрийн магадлах комиссоор тахир дутуугаа тогтоолгосон байхад, 8000 гаруй иргэд буюу 11.6 хувь нь тогтоолгоогүй байна.

Тахир дутуу хүмүүсийн 14 хувь, эрэгтэйчүүдийн 16.3 хувь, эмэгтэйчүүдийн 17.0 хувьд нь байнгын асрамжид байдаг.

Түүвэр судалгааг 2004 оны 6-р сарын 2-28-ны хооронд зохион байгуулсан. Судалгаанд 7 аймгийн 28 сум, 63 багийн 1952 хүн, Улаанбаатар хотоос 6 дүүргийн 12 хорооны 705 хүнээс, бүгд 2657 хүнээс авсан болно.

Судалгаанд хамрагдсан арван тав, түүнээс дээш насны тахир дутуу иргэдийн 36.1 хувь ямар нэг мэргэжил эзэмшсэн байна. Хөдөө амьдарч буй тахир дутуу эмэгтэйчүүдийн 22.4 хувь, эрэгтэйчүүдийн 30.3 хувь нь л ямар нэг мэргэжил эзэмшсэн гэж хариулжээ. Нийт мэргэжил эзэмшсэн тахир дутуу иргэдийн 33.0 хувь нь үйлдвэрийн ба худалдааны ажилтан, 24.4 хувь нь мэргэжилтэн, 22.2 хувь нь машин тоног төхөөрөмжийн операторч, угсрагч, 10.0 хувь нь инженер техникийн ажилтан байна.

Судалгаанд хамрагдсан нийт тахир дутуу иргэдийн нийгмийн халамжийн байгууллагаас тахир дутуу иргэнд үзүүлдэг хөнгөлөлт, үйлчилгээнд 22.6 хувь нь хамрагддаг, 77.4 хувь нь хамрагддаггүй гэсэн хариулт өгсөн байна.

Бүртгэл, судалгааны дүнгээс харахад:

- Тахир дутуу иргэдийн боловсрол эзэмших боломжийг сайжруулах;
- Онцлогт нь тохирсон мэргэжил эзэмшүүлэх, улмаар ажил эрхлэлтийг нь нэмэгдүүлэх;
- Олдмол тахир дутуугийн гол шалтгаан болох ердийн өвчнийг нарийвчлан судлах, урьдчилан сэргийлэхэд
- Тахир дутуу иргэдийн нийгэмд оролцох оролцоог нэмэгдүүлэхдээ хамт олныг түшиглэх;

- Нийгмийн халамжийн байгууллагаас тахир дутуу иргэнд үзүүлдэг хөнгөлөлт, үйлчилгээнд хамрагдалтыг нэмэгдүүлэхэд илүү анхаарал хандуулан ажиллах нь зүйтэй юм.
-